

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

АГУУЛГА

- 1. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААН, ЗОРИЛГО, ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ТӨЛӨВЛӨЛТ.**
- 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.**
 - 2.1. Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
 - 2.2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа.
 - 2.2.1. Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл.
 - 2.2.2. Нийгмийн даатгалын сангийн орлого.
 - 2.2.3. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт.
 - 2.2.4. Нийгмийн даатгалын хамралт.
 - 2.2.5. Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж болон төлбөр, зардал.
 - 2.2.6. Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.
 - 2.2.7. Мэдээлэл технологийн үйл ажиллагаа.
 - 2.2.8. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд.
 - 2.2.9. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал.
 - 2.2.10. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах.
 - 2.2.11. Хяналт шалгалт.
 - 2.2.12. Лавлах үйлчилгээ.
 - 2.3. Салбарын эрх зүйн орчин.
 - 2.3.1. Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.
 - 2.3.2. Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.
 - 2.3.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.
 - 2.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.
 - 2.5. Дотоод үйл ажиллагаа.
 - 2.5.1. Байгууллагын хүний нөөц.
 - 2.5.2. Байгууллагын санхүү төсвийн үйл ажиллагаа.
- 3. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ.**
- 4. ҮНЭЛГЭЭНИЙ ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол Улс
НД	Нийгмийн даатгал
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
НДС	Нийгмийн даатгалын сан
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СЯ	Сангийн яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХТАО	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХАБЭАҮХ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо
ХАБЭМТ	Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл мэндийн төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХМТК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс
ЭМ	Эрүүл мэнд

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө.

Зураг 2. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц.

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны орлогын гүйцэтгэл.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны зарлагын гүйцэтгэл.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны зарцуулсан хөрөнгө болон
үйлчлүүлсэн хүний тоо.

Хүснэгт 5. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө.

Хүснэгт 6. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө.

Хүснэгт 7. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө.

Хүснэгт 8. Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудын бүтэц.

Хүснэгт 9. НД-ын байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо.

Хүснэгт 10. НД-ын байгууллагын албан хаагчдын боловсрол, мэргэжил.

Хүснэгт 11. НД-ын байгууллагын албан хаагчдын нас, хүйсний мэдээлэл.

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Нийгмийн даатгалын сангийн төсөв.

График 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц.

График 3. Нийгмийн даатгалын хамралт.

График 4. Тэтгэврийн зарлага.

График 5. Тэтгэвэр авагчдын бүтэц.

График 6. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ.

График 7. Тэтгэмжийн зарлага.

График 8. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага.

График 9. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө.

График 10. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт 1. Нийгмийн даатгалын салбарын холбогдох эрх зүйн актын 2020 оны хэрэгжилтийн мэдээ.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг Хууль зүйн яам /хуучин нэрээр/-наас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гаргаж, үнэлгээ хийсэн.

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААН, ЗОРИЛГО, ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ТӨЛӨВЛӨЛТ.

Системчилсэн үнэлгээ хийх шалтгаан:

Тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө санхүү оновчтой болсон, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоо шаардлага гарсан.

Системчилсэн үнэлгээний зорилго:

Үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

Системчилсэн үнэлгээний хэлбэр:

Үнэлгээний хэлбэр нь хэрэгжсэн хөтөлбөр болон арга хэмжээнд өгөх хэрэгжилтийн үнэлгээ /ретроспектив/ болно.

Системчилсэн үнэлгээний зорилт:

Үнэлгээний зорилт нь байгууллагын дэвшиүүлсэн зорилго, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, үр нөлөө болон тогтвортой байдлын уялдаа холбоо, хэрэгжилтийг тодорхойлж аль болох системтэй, объектив байдлаар төлөвлөсөн, хэрэгжиж буй болон хэрэгжсэн үйл ажиллагааг үнэлсэн.

Системчилсэн үнэлгээний төрөл:

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрсэнийг тодорхойлоход чиглэсэн бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа.
- Салбарын эрх зүйн орчин.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.
- Дотоод үйл ажиллагаа.

Системчилсэн үнэлгээ хийх урьдчилсан бэлтгэл болон төлөвлөлт:

Зураг 1. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө

Хугацаа		1-р сар	2-р сар	3-р сар									
Хэрэгжүүлбэл зохих ажлууд		→											
Төлөвлөлтийн шат	Үнэлгээний баг бүрдүүлэх		■	■									
	Үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах			■	■								
	Үнэлгээ хийх талаар НДЕГ-т албан бичиг хүргүүлэх				■								
	Тайлан гаргаж өгөх НДЕГ-ын холбогдох мэргэжилтэнтэй уулзах					■							
Үнэлгээний шат	Баримт бичигтэй танилцах							■	■				
	Тайлангийн талаар тодруулга, асуулга авах								■				
	Ярилцлага хийх									■			
	Дүн шинжилгээ хийх									■			
	Дүгнэлт гаргах										■		
	Зөвлөмж бичих									■			
	Тайланг гаргах										■		
	НДҮЗ-ийн хуралдаанд танилцуулах											■	
	УИХ-ын Нийгмийн Бодлогын Байнгын Хороонд хүргүүлэх												■

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.

2.1. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

НДҮЗ нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд нийгмийн даатгалын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын үед үндэсний аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдын санхүүгийн хүндрэлийг шийдэх зорилгоор УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан.

НД-ын салбарын төв байгууллага болох НДЕГ нь нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт


тусгагдсан асуудлын хэрэгжилтийг зохион байгуулах, Нийгмийн даатгалын тухай багц хуулиудын төслийн санал, хэрэгжүүлэхтэй холбоотой журам, зөвлөмж, аргачлал, заавар боловсруулах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг хэтийн болон дунд хугацаанд төлөвлөх, хэтийн тооцоолол хийх, нийгмийн даатгалын сангийн болон салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилах, нийгмийн даатгалын сангийн төлөв байдалд судалгаа, дүгнэлт хийх, статистик үзүүлэлтүүд бэлтгэх, МУ-ын нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын гэрээ, хэлэлцээрийн төслийн санал боловсруулах, төв, орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.

НДҮЗ нь Улсын Их Хурлаас томилогдсон Засгийн газар, Даатгуулагч, Ажил олгогчийг төлөөлсөн тус бүр 3, нийт 9 гишүүнтэй. Ажлын алба нь Улсын Их Хурлын НББСШУБХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 12 орон тоотой ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 04 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар бүтэц, орон тоо, нэгжүүдийн чиг үүргийг 6 газар, 5 хэлтэстэй, дэргэдээ 2 төв, 1 зөвлөл, 1 төв комисс, 1 тасагтай байхаар баталсны дагуу 2020 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Тамгын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү, бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар, Хуулийн хэлтэс, Үйл ажиллагааны хөгжлийн хэлтэс, Судалгааны хэлтэс, Хуримтлалын сан, өрийн удирдлагын хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс гэсэн нэгжүүдэд нийт 82 ажилтан, албан хаагчтай, дэргэдэх Мэдээллийн технологийн төв 9, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс 8, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төвийн Нийгмийн даатгалын тасаг 8 албан хаагчидтай ажилласан.

Мөн орон нутагт нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг хангах, чиг үүрэг бүхий нийслэл, дүүрэг, аймгийн Нийгмийн даатгалын 31 газар, хэлтсүүдэд 1436 ажилтан албан хаагчид Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц



2.2. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.

НД-ын байгууллага нь нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, даатгуулагч, ажил олгогчдыг даатгалд хамруулан бүртгэх, шимтгэлийн орлогыг төвлөрүүлж санг бүрдүүлэх, даатгалын сангаас иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоон олгох, мэдээллийн цахим системийг хөгжүүлэх, даатгуулагч иргэдийн нийгмийн даатгалын талаархи хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг үндсэн үйл

ажиллагаагаа хэрэгжүүлэхээр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22 зорилт 83 арга хэмжээг тусгасан.


НД-ын байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний системчилсэн үнэлгээний дүнг харуулбал:

- Бүрэн хэрэгжсэн 76 арга хэмжээ.
- Хэрэгжих шатанд байгаа 4 арга хэмжээ.
- Үнэлэх боломжгүй буюу цар тахлын улмаас хийгдээгүй ба гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэлгүй 3 арга хэмжээ байгаа бөгөөд нийт хэрэгжилтийн хувь 95.8 байна.

2.2.1. Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар 2,291.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан хуулинд өөрчлөлт орж орлогын хэмжээг 1,812.3 тэрбум төгрөгөөр баталсан. Үүнээс: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1,411.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 1.1 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 399.5 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Мөн хуулиар төсвийн нийт зарлагыг 2,494.1 тэрбум төгрөг үүнээс тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 2,466.9 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 27.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталсан.

График 1. Нийгмийн даатгалын сангийн төсөв (тэрбум.төг)




2.2.2. Нийгмийн даатгалын сангийн орлого.

Нийгмийн даатгалын санд 2020 оны жилийн эцсийн байдлаар шимтгэлийн орлого 1,411.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,477.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 104.6 хувиар биелүүлсэн. /Энэ дүнд эрүүл мэндийн

даатгалаас санхүүжих 1.1 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 399.5 тэрбум төгрөг багтаагүй./

График 2. Нийгмиийн даатгалын сангийн орлогын бүтэц (хувиар)



Нийгмийн даатгалын сангийн нийт орлогын 51.0 хувь буюу 753.6 тэрбум төгрөгийг ажил олгогч, 44.9 хувь буюу 663.8 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 4.1 хувь буюу 60.2 тэрбум төгрөгийг сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулсан мөнгөн хадгаламжийн болон ҮОМШӨ-ний даатгалын сангаас төлсөн шимтгэл, бусад орлогоор тус тус бүрдүүлсэн.

Мөн орлогын 27.0 хувь буюу 399.5 тэрбум төгрөгийг тэтгэврийн болон ҮОМШӨ-ний даатгалын санд улсын төсвөөс, 0.07 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас шилжүүлсэн санхүүжилтийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Нийгмиийн даатгалын сангийн орлогын биелэлт (тэрбум.төг)

№	Орлогын төрөл	2019		2020
		2019	2020	2020
1	Улсын төсвөөс олгох дэмжлэг	605.5	399.5	
2	Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас	775.8	463.6	
3	Төсөвт газраас	220.3	290.1	
4	Даатгуулагчаас	701.2	522.9	
5	Сайн дурын даатгуулагчаас	88.4	138.0	
6	Гадаадад ажиллаж буй иргэдийн	3.0	2.8	
7	ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн	1.2	1.6	
8	ЭМД-ын сангаас санхүүжих	-	1.1	
9	Бусад орлого	89.6	58.6	
Нийт		2,485.0	1,878.2	

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны орлогын гүйцэтгэл

№	Орлого	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт орлогод эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	1,595.4	84.9
2	Тэтгэмжийн даатгалын сан	111.4	5.9
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	145.5	7.8
4	Ажилгүйдлийн даатгалын сан	25.9	1.4
Нийт		1,878.2	100.0

Арилжааны банкуудад хугацаатай мөнгөн хадгаламж байршуулж, 32.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.

2.2.3. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт.

Нийгмийн даатгалын сангийн зардлын төсөв 2,494.1 тэрбум төгрөг бөгөөд 2,451.8 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд олгосон.

Хүснэгт 3. НДС-ийн 2020 оны зарлагын гүйцэтгэл

№	Зардал	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт зардалд эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	2,153.6	87.8
2	Тэтгэмжийн даатгалын сан	145.4	5.9
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	31.6	1.3
4	Ажилгүйдлийн даатгалын сан	94.4	3.9
5	Үйл ажиллагааны зардал	26.8	1.1
Нийт		2,451.8	100.0


Хүснэгт 4. НДС-ийн 2020 оны зарцуулсан хөрөнгө болон үйлчлүүлсэн хүний тоо

№	Нийгмийн даатгалын сан	2018 он		2019 он		2020 он	
		Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/
1	Тэтгэврийн	398.1	1,619.3	412.9	1,839.2	437.1	2,153.6
2	Тэтгэмжийн	209.6	112.1	210.3	124.1	191.2	145.4
3	ҮОМШӨ-ний	9.4	29.9	8.7	30.8	7.6	31.6
4	Ажилгүйдлийн	21.4	34.3	23.1	43.6	21.3	94.4
5	Үйл ажиллагааны зардал	-	18.9	-	24.5	-	26.8
Нийт		638.6	1,814.5	655.0	2,062.2	657.2	2,451.8

Нийгмийн даатгалын сангаар үйлчлүүлсэн иргэдийн тоо 2.2 мянга буюу 0.3 хувиар, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 389.6 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар тус тус өссөн бөгөөд Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 26.8 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 9.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.2.4. Нийгмийн даатгалын хамралт.

График 3. Нийгмийн даатгалын хамралт (мян.хүн)



Нийгмийн даатгалын мэдээллийн санд 2020 оны жилийн эцсийн байдлаар 49.3 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн нь 2019 онтой харьцуулахад 1.1 мянган ажил олгогч буюу 2.2 хувиар нэмэгдсэн.

Мөн албан журмын болон сайн дурсын даатгалд 1,146.5 мянган даатгуулагч хамрагдсан нь нийт ажиллах хүчний 94.2 хувийг эзэлж байна. /Үндэсний статистикийн 2020 оны 4-р улирлын тоон мэдээгээр нийт ажиллах хүчний тоо 1,216.6 мянган хүн/

2.2.5. Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж болон төлбөр, зардал.

Тэтгэврийн даатгалын сан.

2020 оны тайлант жилд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн албан хаагчийн тэтгэвэр авч байгаа 437.1 мянган тэтгэвэр авагчид 2,151.0 тэрбум төгрөг зарцуулсан.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 52.7 мянган тэтгэвэр авагч, 19.1 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 383.5 тэрбум төгрөг зарцуулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хүснэгт 5. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тэтгэврийн төрөл	2018 он		2019 он		2020 он	
		Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/
1	Өндөр насын	293.7	1,222.5	307.5	1,396.9	332.9	1,663.9
2	Тахир дутуугийн	66.3	208.2	67.0	230.9	65.9	255.8
3	Тэжээгчээ алдсаны	20.2	64.1	19.8	70.1	19.2	77.6
4	Цэргийн	17.8	122.8	18.6	139.4	19.1	153.7
Нийт		398.1	1,617.6*	412.9	1,837.3*	437.1	2,151.0

* Бусад зардал ороогүй болно.

График 4. Тэтгэврийн зарлага (тэрбум.төг)





График 5. Тэтгэвэр авагчдын бүтэц (хувиар)


Нийт өндөр насын тэтгэвэр авагчдын 7.5 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 92.5 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.

2020 оны байдлаар нийгмийн даатгалын сангаас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс /2020 онд Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин сарын 230.0 мянган төгрөг/ 152.2 хувиар илүү байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

График 6. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ (мян.төг)



Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 10.5 хувиар өссөн байна.

Тэтгэмжийн даатгалын сан.

Тэтгэмжийн даатгалын сангаас 191.2 мянган даатгуулагчдад 143.0 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгосон.

Хүснэгт 6. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тэтгэмжийн төрөл	2018 он		2019 он		2020 он	
		Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	133.9	17.9	132.9	19.8	113.7	20.2
2	Жирэмсний болон амаржсаны	61.5	79.9	63.4	90.2	64.6	109.9
3	Оршуулгын	14.1	14.1	13.9	13.9	12.9	12.9
4	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмж	-	-	-	-	83.7	2.2
Нийт		209.5	111.9*	210.2	124.0*	274.9	145.2*

* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.2 тэрбум төгрөгөөр буюу 17.0 хувиар нэмэгдсэн.

График 7. Тэтгэмжийн зарлага (тэрбум.төг)

**ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САН.**

2020 оны жилийн эцсийн байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 4.4 мянган иргэний тэтгэвэрт 27.7 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1.1 мянган иргэний тэтгэмжид 0.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд 2.1 мянган иргэнд 1.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 7. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	2018 он		2019 он		2020 он	
		Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум.төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум.төг/	Тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум.төг/
1	Тахир дутуугийн тэтгэвэр	4.3	23.9	4.0	24.2	3.9	24.8
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.6	2.6	0.5	2.7	0.5	2.9
3	ХЧТА-ны тэтгэмж	1.1	0.7	1.1	0.7	1.1	0.9
4	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.02	0.02	0.02	0.02	0.02	0.02
5	Рашаан сувиллын зардал	3.4	0.9	3.2	0.9	2.1	0.6
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	0.8	-	1.0	-	0.7
7	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл	-	0.9	-	1.2	-	1.6
Нийт		9.4	29.9*	8.8	30.8*	7.6	31.5*

* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

Сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

График 8. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/




Ажилгүйдлийн даатгалын сан.

2020 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 21.4 мянган даатгуулагч 50.2 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх хуулийн хүрээнд 44.1 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон.

График 9. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө



2.2.6. Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

УИХ-аас КОВИД-19 цар тахлын үед аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-ийг баталсан. Дээрх хуулийн үйлчлэлд төрийн байгууллагаас бусад бүх аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчид 2020 оны 04 дүгээр сараас эхлэн хамрагдсан. Үүнд:

- 2020 оны 04 дүгээр сараас 2020 оны 10 дугаар сар хүртэл 6 сарын хугацаанд ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлсөн;

- 2020 оны 10 дугаар сараас 2021 оны 01 дүгээр сар хүртэл 3 сарын хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч тус бүр 5 хувиар төлж, бусад даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн.

2020 онд хэрэгжүүлсэн шимтгэлээс чөлөөлөх, хөнгөлөх арга хэмжээнд урьдчилсан байдлаар 38.4 мянган ажил олгогч, 571 мянган даатгуулагч, үүнээс 156.5 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж, нийт дүнгээр 713.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн. Мөн хуулийн хүрээнд ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган аж ахуйн нэгжийн 80.9 мянган даатгуулагчид 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон.

Үүнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс 5 тогтоол баталж, шаардагдах хөрөнгийг нийгмийн даатгалын сан хооронд шилжүүлэн зарцуулах шийдвэр гарган дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангасан.

2.2.7 Мэдээлэл, технологийн үйл ажиллагаа.

Энэ онд шинээр 5 програм хангамж боловсруулан нэвтрүүлсэн. Үүнд:

“Нөхөн даатгал 2020” 1995 – 2019 оныг дуустал нөхөн даатгалд хамрагдах малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний мэдээллийг бүртгэх, нөхөн төлөх шимтгэлийг тооцох, нөхөн төлөх хүсэлт болон баталгаажилтын хуудас хэвлэх зориулалт бүхий вэб програмд бүртгэсэн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн мэдээллийг УБЕГ, ТЕГ, БСШУЯ, ХХҮЕГ-ын мэдээллийн сангаас цахимаар шалгах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү програмд 4.2 мянган малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн мэдээллийг бүртгэж, 2.9 мянган иргэний баталгаажуулалтын хуудсыг хэвлэсэн.

“Сайн дурын даатгуулагч эх-HYBRID” хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа эхийн сайн дурын даатгалыг бүртгэх зориулалт бүхий програм бөгөөд 3 нас хүртэлх хүүхдээ асрах чөлөөтэй байгаа 14.2 мянган даатгуулагч эхийн мэдээлэл бүртгэгдсэн. Эх өөрөө, мөн төсөв болон сангаас шимтгэлийг төлөх боломж бүрдсэн.

“Сайн дурын даатгалын онлайн систем” иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг орон зайд, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр авах ажлыг өргөжүүлэх хүрээнд нэвтрүүлсэн. Уг систем нь иргэд, даатгуулагчдад зориулсан сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөр төлөх үйлчилгээг цахимаар үзүүлэх “Даатгуулагчид зориулсан онлайн систем”, нийгмийн даатгалын байцаагч ажилтнууд холбогдон ажиллах “Байцаагч ажилтанд зориулсан систем”-ээс тус тус бүрддэг.

Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөр төлөх үйлчилгээг нийгмийн даатгалын байгууллагад өөрийн биеэр ирэлгүйгээр гар утаснаасаа “Нийгмийн даатгал” аппликацийнээр авах боломжийг бүрдүүллээ. Уг системийг нэвтрүүлснээр 964 даатгуулагч сайн дурын үйлчилгээ авсан.

“Цахим архивын лавлагаа” Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд цаасан хэлбэрээр

хадгалагдан ашиглагдаж байсан 1995 – 2005 оны НД-7, НД-8 тайлангуудыг цахим хэлбэрт шилжүүлэх, үүнтэй уялдан даатгуулагчдын тухайн онуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг цахимд суурилан гаргах зориулалт бүхий програм хангамж юм. Даатгуулагчийг аймаг, сум, дүүрэг хооронд явуулж чирэгдэл учруулахгүйгээр тухайн нэгжийн архивын ажилтан шууд хэвлэж өгөх боломж бүрдсэн.

УИХ-аас шинээр баталсан хууль, Засгийн газрын тогтоол, журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10 програм хангамжид нийтдээ 170 гаруй удаагийн өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн.

Азийн хөгжлийн банк төслийн хүрээнд нийт 3 багц, 14 нэр төрлийн 1,672.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 3 багц, 13 нэр төрлийн 3,931.51 сая төгрөгийн програм хангамж, лицензийг шалгаж хүлээн авсан.

Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг баяжуулсан. Үүнд:

- Нэгдсэн мэдээллийн санг баяжуулан 74GB өгөгдөл нөөцлөн хадгалсан.
- 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 1995 – 2005 оны нийгмийн даатгалын шимтгэлийн цаасан суурьт тайланг цахимжуулж, 2.4TB мэдээллийн санг үүсгэсэн.
- Гар утасны аппли케йшнийг 121.0 мянган даатгуулагч идэвхитэй ашиглаж байгаа бол 261.0 мянган иргэд даатгуулагч өөрийн нийгмийн даатгалын үйлчилгээний мэдээллээ интернэтээс харах, хэвлэн авах боломж бүхий вэб програмд хандсан.
- Улсын хэмжээнд ашиглагдаж буй 109 ТҮЦ машинаас 4 төрлийн 180.0 мянга орчим лавлагаа, тодорхойлолт хэвлэн авсан.
- 92.4 мянган иргэд даатгуулагч, 22.7 мянган ажил олгогч QR кодтой лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан бол QR кодтой лавлагаа тодорхойлолтыг шалгах вэб програм хангамжаар 62.6 мянган даатгуулагч, 11.0 мянган ажил олгогчийн лавлагаа тодорхойлолтыг шалгасан.
- Хур систем, ТҮЦ, Төрийн нэг цэгийн үйлчилгээний төв, НДХ-үүдэд хэвлэдэг лавлагаа болон бусад хандалтын тоо 5.4 сая, мэдээлэл солилцдог төрийн байгууллагуудын сервисийн хандалт 2.8 сая, ажил олгогчийн “Шимтгэлийн цахим систем”-ийн хандалт 529.1 мянгад хүрсэн.
- Төрийн цахим үйлчилгээний e-mongolia нэгдсэн порталаар 3 төрлийн лавлагаа, тодорхойлолт өгсөн.

2.2.8 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд.

Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод зориулсан сошиал хуудсаар нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөөг ойлгомжтой, хялбар, зурган хэлбэрээр байршуулах, иргэдийн бичсэн сэтгэгдэл тухай бүр хариу өгөх, мессежээр зөвлөгөө өгөх, “нийгмийн даатгал” аппликеийн суулгах ашиглах заавар өгөх, баталгаажуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зэрэг үйлчилгээг үзүүлэв. Одоогоор энэхүү сошиал хуудсыг 15.1 мянган иргэн дагаж байгаа бөгөөд гадаад

оронд ажиллаж амьдарч байгаа 300 гаруй иргэд холбогдсон байна. Хандалтын хувьд авч үзвэл зөвлөгөө, мэдээлэлтэй танилцсан нийт 960.4, үүнээс эргэж холбогдсон 80.1 мянга, таалагдсан 14.6 мянга, сэтгэгдэл үлдээсэн 2.4 мянга, бусдад түгээсэн 6.0 мянган хэрэглэгч байна. Мессежээр нийт 8.9 мянган иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан.

“Шинрай” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Нийгмийн даатгалын байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээнд олон улсын стандартыг хэвшүүлэх нь” сэдэвт сургалтыг 5 дугаар сард зохион байгуулж, төрийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх арга зам, байгууллагын төлөв байдал, процессын хандлага, манлайлал, эрсдэлд суурилсан сэтгэлгээ, байгууллага дахь мэдлэг ба баримтжуулсан мэдээлэл, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудит, байнгын сайжруулалт, түүнд нөлөөлөх амжилтын хүчин зүйлс, нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний соёл зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгсөн.

Нийгмийн даатгалын салбарын 550 гаруй албан хаагчдыг нэгтгэсэн Нийгмийн даатгал-ISO 9001:2015 фэйсбүүк групп нээж, “Чанарын удирдлагын тогтолцоо ба түүний зорилго, ач холбогдол”, “ISO 9001:2015 стандарт ба шаардлагууд”, “Гүйцэтгэлийг хэмжих дасгал ажлын хариу”, “ISO 9001:2015 стандартын цуврал хичээлүүд”, “Ажилтан таны үнэ цэнэ юу вэ” зэрэг чанарын удирдлагын тогтолцоо, стандартын талаарх нийт 20 гаруй зурган болон видео, слайд, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн туршлага зэрэг мэдээ, мэдээллийг байршуулж, харилцан санал солилцсон.

“Албан бус эдийн засагт ажиллагсдын нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, олон улсын туршлага, сургамжийн эмхэтгэл”-ийг монгол хэлнээ орчуулах, хэвлүүлэх талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулан төрийн болон төрийн бус байгууллага, албан бус эдийн засагт ажиллагсадад зориулсан олон улсын туршлагыг үндэслэн танилцуулга бэлтгэх, гурван талт мэргэжилтнүүдийн зөвлөгөөн зохион байгуулах үүрэг бүхий зөвлөх ажиллуулахаар гэрээ байгуулан 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан.

2.2.9. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал.

Улсын хэмжээнд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор тогтоогдсон хөдөлмөрийн чадвараа алдсан 110 393 иргэн байгаагаас нийгмийн даатгалын сангаас 72 163, нийгмийн халамжийн сангаас 38 230 иргэн тэтгэвэр, тэтгэмж авсан.

Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 9 533, сунгуулсан 100 950, цуцлуулсан 9 417, нас барсан 2 260, хөдөлмөрийн нөхцөл сольсон 66, ажлын цаг хорогдуулсан 9 иргэн (даатгуулагч) байна.

Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 1 206 иргэдийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь, хугацаа, тэтгэвэр олгож буй үндэслэлийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын цахим мэдээллийн сангийн бүртгэлтэй тулган шалгаж, дотоод хяналтаар нийт 3 136 иргэнийг дахин магадлалд хамруулж, 43 270 иргэний мэдээллийг шалгаж, 20 000

гаруй тахир дутуугийн тэтгэвэр авагч (давхардсан тоогоор)-ийн бүртгэлийн зөрүүг арилгуулах арга хэмжээ авсан.

Авиалгатай тэмцэх газарт шалгагдаж байгаа хэрэгт магадлагч эмч нарыг шинжээчээр томилон ажиллуулж, 400 гаруй иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байдлыг хянасан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гишүүн орнуудад зөвлөмж болгож буй “Ижил мэргэжилтний үзлэг”-ийг нийгмийн даатгалын салбарт анх удаа нэвтрүүлж, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт 2019 – 2020 онд нийт 6 удаа зохион байгуулсан.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хууль, эрх зүйн 18 баримт бичгийг баталснаас гадна “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”, “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай” Сайдын тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн.

2.2.10. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах.

Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны талаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах чиглэлээр анхаарч ажилласан.

2020 онд зэрэг 101 хэвлэл мэдээллийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 746 удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр ханган ажилласан. Мөн нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлт, нийгмийн даатгалын ач холбогдол, сайн дурын даатгал, цахим үйлчилгээ, шинэ үйлчилгээ, нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт, тэтгэврийн нэмэгдэл, зээл чөлөөлөлт зэрэг олон нийтэд хүргэх шаардлагатай салбарын мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 1 239 удаагийн давтамжтайгаар түгээж, 50 мэдээ, 11 ярилцлага, 247 постер мэдээлэл, 5 хэвлэлийн мэдээ, 4 хэвлэмэл материал, 4 нэвтрүүлэг шторкны зохиол, 3 нийтлэлийг олон нийтэд хүргэсэн.

Нийгмийн даатгалын салбарын ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгын хүрээнд 422 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 6 986 албан хаагчийг хамруулсан. Мөн ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр 1 467 удаагийн сургалтад 154 708 иргэд, даатгуулагчийг хамруулсан.

Ажил олгогч байгууллагуудад 846 удаа, 64 426 албан хаагчид, баг хороодод 609 удаа, 78 727 иргэдэд, их, дээд сургууль, 10 жилийн сургууль, МСҮТ-ийн 7 722 оюутан, сурагчдад 141 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн нийгмийн

даатгалын явуулын үйлчилгээгээр 1 232 удаа 60 278 иргэдэд, нээлттэй өдөрлөгөөр 119 удаа 89 072 иргэнд тус тус нийгмийн даатгалын чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгсөн.

2.2.11. Хяналт шалгалт.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулдаг 4 аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, 2 аж ахуйн нэгжтэй холбоотой нийт 9.5 сая төгрөгийн цалингийн сангаас нийгмийн даатгалын шимтгэл тооцож төлөөгүй зөрчлийг илрүүлэн 2.2 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлсэн.

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2020 онд 96 даатгуулагчид олгосон 62.4 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл тооцож төлөөгүй зөрчил илрүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу 14.9 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож 73.1 хувийг барагдуулсан.

Тайлант жилийн хугацаанд иргэд даатгуулагчаас нийт 364 өргөдөл ирүүлснээс 351 буюу 96.4 хувийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн бөгөөд тэтгэврийн тогтоолт, олголтын тухай асуудлаар 194 буюу нийт өргөдлийн 53.2 хувь, тэтгэмжийн асуудлаар 61 буюу 16.7 хувь бусад асуудлаар 109 буюу 30.1 хувийг тус тус эзэлж байна.

Цахим хяналтын вэб програм (<http://10.9.0.5/monitoring>)-аар зөрчилтэй байх магадлалтай 186.4 мянган нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах явцад 149.9 мянган даатгуулагчийн 01 код давхцуулсан болон бусад 7 төрлийн зөрчил гарсан. Үүнээс 121.4 мянган даатгуулагчийн мэдээллийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагатай тооцоо нийлж залруулсан.

2.2.12. Лавлах үйлчилгээ.

Лавлах үйлчилгээг өргөжүүлэн “Дуудлагын төв – 7777 1289” болгосноор мэдээллийн ажилтнаас гадна автомат хариулагчаас нийгмийн даатгалын мэдээллийг 24 цагийн турш өгч байна. Хүчин чадал нэмэгдсэнээр дуудлага алдалт буурч, давхар дуудлагыг бүртгэн авч эргэн холбогдох, мөн үйлчлүүлэгчийн дуудлагын түүхийг бүртгэнээр өмнө нь ямар төрлийн мэдээлэл зөвлөгөө авч байсныг харах боломжтой болсон.

Дуудлагын төвөөр нийт 105 754 иргэн хандсанаас 57 960 нь үйлчилгээний ажилтантай холбогдож, 38 612 нь автомат хариулагчаас мэдээлэл, зөвлөгөө авч, 1 037 иргэн автомат хариулагчийн мэдээлэл үлдээх хэсэгт асуулт үлдээж, 8 145 дуудлага алдсан байна.

Автомат хариулагчаас авсан мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл тэтгэвэртэй холбоотой 7 062, тэтгэмжтэй холбоотой 7 829, сайн дурын даатгалтай холбоотой 12 573, ЭХМТК-той холбоотой 1 852, тайлан, тооцоотой холбоотой 9 296 иргэн мэдээлэл авсан.

2.3 САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.

2.3.1. Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.

Ковид-19 цар тахлын үед аж ахуйн нэгж, даатгуулагчдийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэв.

Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж байгаа аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрт ажиллаж байгаа даатгуулагчийг дэмжих зорилгоор гаргасан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.

Хуулийн хүрээнд 38.4 мянган ажил олгогч, 410.6 мянган даатгуулагч болон 156.5 мянган сайн дурын даатгуулагч хамрагдаж, нийт 713.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган аж ахуйн нэгжийн 80.9 мянган даатгуулагчид 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон. Үүнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтоол гаргаж шаардагдах хөрөнгийг нийгмийн даатгалын сан хооронд шилжүүлэн зарцуулах шийдвэр гаргасан.

Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг чөлөөлөв.

Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-ийг хэрэгжүүлж, 228.6 мянган тэтгэвэр авагчийн 694.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр барьцаалсан зээлийг чөлөөлсөн. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлээс арилжааны 8 банкинд 694.7 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар 6 хувийн хүүтэй байршуулсан.

Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалыг батлуулсан.

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын 2018 оны А/73 дугаар тушаалын дагуу холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулсан Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсэг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудын төслийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн 6 бүлэг 36 зүйл, 111 хэсгийг нэг бүрчлэн хэлэлцэн уг хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээ, зарим нэр томьёоны тодорхойлолт, тэтгэврийн даатгалд шимтгэл төлж даатгуулсан иргэнд олгох тэтгэврийн төрөл, хугацаа, эрх үүсэх нөхцөл, тэтгэвэр тогтоох, өөрчлөх, олгохтой холбогдсон харилцаа, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо, өндөр наасны тэтгэвэр тогтоолгох

сонголт хийх эрх, Монгол Улсын тэтгэврийн тогтолцоог шинэчлэх, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, Нийгмийн даатгалын хуулиудад заасан нөхцлийг хангасан даатгуулагч бүр суурь тэтгэвэр авах, хоёр давхаргын тэтгэврийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны арга”-аар тооцох, гурав дахь давхарга буюу хувийн нэмэлт тэтгэврийн давхаргатай байх зэрэг шинэчлэлийн асуудлыг тусган боловсруулсан.

Зарим иргэдийн тэтгэврийн хэмжээг 50 000 төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах журам”-д зааснаар 1990 оны БНМАУ-ын тэтгэврийн хуулийн дагуу:

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн, 15-аас доошгүй жил ажиллаж 50 насанд хүрсэн нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эх;
- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн, 20-оос доошгүй жил ажиллаж нас харгалзахгүй нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эх;
- Нийтдээ 27-гоос дээш жил ажиллаж нас харгалзахгүй нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй;
- Нийтдээ 32-оос дээш жил ажиллаж 55 насанд хүрсэн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй гэсэн хөнгөлөлттэй нөхцөл, болзол хангасан зарим иргэдийн тэтгэврийг 50 000 төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэв.

“Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”, Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна. Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахад БШУЯ, ТЕГ, ЦЕГ, ШШГЕГ, ХХҮЕГ-тай хамтарсан тушаал батлан иргэний бүрдүүлбэл зохих тодорхойлолт, баримт бичгийг төрийн байгууллагуудаас цахимаар авч нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчид чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх чиглэлээр ажилласан. Энэхүү хуулийн дагуу 16.2 мянган малчин, 1.3 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 17.7 мянган хүн 34.5 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлж, 2020 онд шимтгэл нөхөн төлсөн 8 348 иргэн шинээр тэтгэвэр тогтоолгон, тэдгээрийн тэтгэвэрт 15.9 тэрбум төгрөг зарцуулсан.

2.3.2. Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн.

Засгийн газрын 2020 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 24 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулан 426.5 мянган тэтгэвэр авагч хамрагдаж,

нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн алба хаасны 500.0 мянган төгрөг хүртэлх тэтгэврийг 30.0 мянган төгрөгөөр, 500.0 мянга болон түүнээс дээш төгрөгийн тэтгэврийг 25.0 мянган төгрөгөөр, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 40.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. Уг арга хэмжээний дүнд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 300.0 мянган төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 416.1 мянган төгрөгт хүрч, тэтгэвэр дунджаар 8.0 хувиар нэмэгдэв. Тэтгэврийн нэмэгдэлд 150.0 тэрбум төгрөгийг зарцуулсан.

3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг хангаж 50 хувийн шимтгэлийг төлөв.

Эхчүүдийн хүүхдээ 3 нас хүртэл нь асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг төлсөн тохиолдолд үлдсэн хувийг тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс хариуцан төлүүлэх ажлыг зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд 17.1 мянган эхийг сайн дурын даатгалд хамруулснаар нийт 6.3 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг бүрдүүлсэн. Үүнээс тэтгэмжийн даатгалын сангаас 1.8 тэрбум төгрөгийн шимтгэлийг хариуцан төлж, 1.9 тэрбум төгрөгийн шимтгэлийг 9 мянган даатгуулагч эх өөрөө төлсөн. Харин улсын төсвөөс 1.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг, 8 мянган даатгуулагч эх өөрөө 1.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг тус тус хариуцан төлсөн.

Ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран 100 хувиар тэтгэмж олгов.

Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 100 хувиар тооцон олгох ажлыг зохион байгуулан тэтгэмжийн даатгалын сангаас нийтдээ 11.3 мянган даатгуулагч эхэд 10.1 тэрбум төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хугацаанд нь бүрэн олгосон.

Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэв.

Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авч 6 нас хүртэл өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг 1 жилийг 1 жил 6 сараар нэмэгдүүлэн тооцож тэтгэвэр тогтоох ажлыг шинээр зохион байгуулан, 22.9 мянган эхийн төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авч, 6 нас хүртэл өсгөсөн хүүхдийн тоогоор нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэмэгдүүлэн өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоосноор эхчүүдийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн жил дунджаар 5 жилээр нэмэгдэн, тэтгэвэр нь 7.5 хувиар илүү тогтоогдож, уг нэмэгдсэн жилд ногдох тэтгэвэрт 10.5 тэрбум төгрөг зарцуулсан.

2.3.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь 2020 онд нийт 9 удаа хуралдаж, 18 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 11 тогтоол гаргасан.

КОВИД-19 цар тахлын үед аж ахуйн нэгж, даатгуулагчдын санхүүгийн хүндрэлийг шийдэх арга хэмжээг авсан.

КОВИД-19 цар тахлын үед аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдын санхүүгийн хүндрэлийг шийдэх нэг арга хэмжээ болгож УИХ-аас Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг баталсан. Энэ хуулийг хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс дараах тогтоолуудыг баталж гарган нийгмийн даатгалын сан хооронд 588.3 тэрбум төгрөгийн шилжүүлэг хийж, дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангасан. Үүнд:

- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 06 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас ажилгүйдлийн даатгалын сан руу шилжүүлэх хөрөнгийн хэмжээг 64.0 тэрбум төгрөгөөр батлан нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн нарийвчилсан хуваарьт холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, батлан мөрдүүлсэн.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 07 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг 210.9 тэрбум төгрөгөөр баталж, аймаг, дүүргийн төсвийн хуваарьт холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 08 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг 377.4 тэрбум төгрөгөөр тогтоон, “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2020 оны тодотгосон төсвийн хуваарь”-ийг тус тус баталсан.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 09 дүгээр тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг 588.3 тэрбум төгрөгөөр баталж, аймаг, дүүргийн төсвийн хуваарьт холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 10 дугаар тогтоолоор Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг 271.2 тэрбум төгрөгөөр тогтоон, “Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг батлан мөрдүүллээ.

Ахмадуудын зээлийг тэглэхийн тулд мөнгөн хадгаламжийг хөнгөлөлттэй хүүгээр байршуулсан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 5 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Журам батлах тухай” 50 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн арилжааны 8 банкинд 694.7 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртлэх хугацаагаар 6 хувийн хүүтэй байршуулахаар шийдвэрлэсэн.

Мөнгөн хадгаламжийн гэрээний загварт нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 05 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар”-ийн 2.3 дэх хэсгийг “Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд Хадгалагчид ажлын 7 өдрийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд Хадгалагч нь Хадгалуулагчид энэхүү гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хугацаанд олгосон хадгаламжийн хүүгийн мөнгөн дүнг 5 хувиар бууруулж тооцон хүүг олгоно.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Даатгуулагчдын нэрийн дансны 2020 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоолоо.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 11 дүгээр тогтоолоор Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”, Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн саналын дагуу даатгуулагчдын нэрийн дансны 2020 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 9.0 хувиар тогтоосон.

2.4. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын алба хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн дагуу тус улсын тэтгэврийн даатгалд хамрагдан шимтгэл төлж байсан иргэдийн шимтгэлийн мөнгийг буцаан олгуулах ажлыг гүйцэтгэж байна. БНСУ-д гэрээгээр ажиллах иргэдэд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалтыг Лхагва гараг бүр ХХҮЕГ-ын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газартай хамтран зохион байгуулж, 29 иргэнтэй гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэн оруулсан. Мөн 7 870 даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтрээ буцаан авч, 113 даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээсэн. Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 2020 онд 72 иргэн 200.2 сая вонн нэхэмжилж, 66 иргэн 175.8 сая вонны шимтгэлээ буцаан авчээ. 6 иргэний 24.4 сая вонны нэхэмжлэх шалгагдаж байна.

Монгол улсаас ОХУ-д ажилласан хугацаагаа баталгаажуулах, Украян болон ОХУ-ын тэтгэврийн фондоос ирүүлсэн ажилласан жилээ баталгаажуулахыг хүссэн нийт 86 иргэний /давхардсан тоогоор/ асуудлыг шийдвэрлэсэн.

2.5. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА.

2.5.1. Байгууллагын хүний нөөц.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 04 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/22 дугаар тушаалаар нийгмийн даатгалын салбарын бүтэц, орон тоог тогтоосон. Салбарын хэмжээнд батлагдсан орон тоогоор 1 436 ажилтан, албан хаагч ажиллаж байна.

Хүснэгт 8. НД-ын салбарын ажилтнуудын бүтэц

№	Албан тушаалын ангилал	Тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	42	2.9
2	Гүйцэтгэх албан тушаалтан	1,233	85.9
3	Үйлчилгээний	93	6.5
4	Гэрээт ажилтан	68	4.7
Нийт		1,436	100

Хүснэгт 9. НД-ын байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо

№	Төрийн албан тушаалын ангилал	Тоо
1	Жинхэнэ албан хаагч	1,275
2	Төрийн үйлчилгээний албан хаагч	93
3	Гэрээт ажилтан	68
4	Үүнээс: Улсын байцаагч	852

Хүснэгт 10. НД-ын байгууллагын албан хаагчдын боловсрол, мэргэжил

№	Боловсролын зэрэг	Тоо	Мэргэжил	Тоо
1	Доктор	2	Санхүүч, Эдийн засагч, Нягтлан бодогч	973
2	Магистр	103	Эрх зүйч	85
3	Бакалавр	1 251	Бусад мэргэжил	293
4	Бүрэн дунд	70	-	-
5	Тусгай дунд	10	-	-

Хүснэгт 11. НД-ын байгууллагын албан хаагчдын нас, хүйсний мэдээлэл

№	Нас	Тоо	Хүйс	Тоо
1	30 хүртэлх	301	Эрэгтэй	397
2	31 – 40	785	Эмэгтэй	1 039
3	41 – 50	276	-	-
4	51 – 60	74	-	-


Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 119 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын 77 албан хаагчийн 51 албан тушаалын тодорхойлолт, 121 дүгээр тогтоолоор Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын 19 албан хаагчийн 10 албан тушаалын тодорхойлолт, 122 дугаар тогтоолоор 21 аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 610 албан хаагчийн 31 албан тушаалын тодорхойлолт, 120 дугаар тогтоолоор Нийслэлийн 9 дүүргийн 320 албан хаагчийн 46 албан тушаалын тодорхойлолт буюу салбарын 1 000 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авч, албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 16 арга хэмжээтэй батлан, биелэлтийг ханган ажилласан. 2020 онд дэлхий нийтээр коронавируст цар тахалтай тэмцэж байгаа энэ цаг үед Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Засгийн газрын болон Улсын онцгой комиссоос гаргасан заавар зөвлөмж, тушаал шийдвэрийг чанд мөрдөн ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан, албан хаагчдыг цар тахлын үед гэрээсээ буюу цахимаар ажиллах боломжоор ханган ажиллаж, ажилтан, албан хаагчдад олон шүүлтүүрт амны хаалт, 16 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт, 107 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгосон.

2.5.2. Байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаа.

Нийгмийн даатгалын байгууллагын 2020 оны үйл ажиллагааны зардалд 27.2 тэрбум төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 26.8 тэрбум төгрөгийг зарцуулж 0.4 тэрбум төгрөгийг хэмнэсэн. Энэхүү хэмнэлт нь төсвийн сахилгга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, хэмнэлтийн горимоор ажилласантай холбоотой. Нийт урсгал зардлын 70.9 хувь буюу 19.0 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын салбарын 1.4 мянган ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан.

График 10. НД-ын байгууллагын үйл ажиллагааны зардал /тэрбум төгрөг/



ГУРАВ. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь системчилсэн үнэлгээнд хамрагдах хугацаанд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016 – 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэл, Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2019 – 2022 он)-ийг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Ковид-19 цар тахлын үед аж ахуйн нэгж, даатгуулагчдийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэв.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжүүлж, 38.4 мянган ажил олгогч, 410.6 мянган даатгуулагч, 156.5 мянган сайн дурын даатгуулагчид нийт дүнгээр 713.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн. Мөн хуулийн хүрээнд ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган аж ахуйн нэгжийн 80.9 мянган даатгуулагчид 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон.

Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг чөлөөлөв.

Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг нэг удаа чөлөөлөх хуулийн дагуу 228.6 мянган тэтгэвэр авагчийн 694.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр барьцаалсан зээлийг чөлөөлсөн.

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн алба хаасны 500.0 хүртэлх төгрөгийн тэтгэврийг 30.0 мянган төгрөгөөр, 500.0 мянга болон түүнээс дээш төгрөгийн тэтгэврийг 25.0 мянган төгрөгөөр, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 40.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 300.0 мянган төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 416.1 мянган төгрөгт хүргэсэн.

Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалыг батлуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулиудын төслийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг боловсруулсан.

Зарим иргэдийн тэтгэврийн хэмжээг 50 000 төгрөгөөр нэмэгдүүлэн олгов.

“Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах журам”-д зааснаар хөнгөлөлттэй 4 нөхцөл, болзол хангасан зарим иргэдийн тэтгэврийг 50 000 төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон.

3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг хангаж 50 хувийн шимтгэлийг төлөв.

17.1 мянган эхийг сайн дурын даатгалд хамруулан, нийт 6.3 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг бүрдүүлснээс тэтгэмжийн даатгалын сангаас 1.8 тэрбум төгрөгийн шимтгэлийг хариуцан төлж, 1.9 тэрбум төгрөгийн шимтгэлийг 9.0 мянган даатгуулагч эх өөрөө төлсөн байна. Харин улсын төсвөөс 1.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг, 8.0 мянган даатгуулагч эх өөрөө 1.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг тус тус хариуцан төлсөн.

Ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран 100 хувиар тэтгэмж олгов.

Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 100 хувиар тооцон олгох ажлыг зохион байгуулан тэтгэмжийн даатгалын сангаас нийтдээ 11.3 мянган даатгуулагч эхэд 10.1 тэрбум төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хугацаанд нь бүрэн олгосон.

Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэв.

Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авч 6 нас хүртэл өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг 6 сараар нэмэгдүүлэн тооцож тэтгэвэр тогтоох ажлыг шинээр зохион байгуулан, 22.9 мянган эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэмэгдүүлэн тэтгэвэр тогтоосноор эхчүүдийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн жил дунджаар 5 жил нэмэгдэн, тэтгэвэр нь 7.5 хувиар илүү тогтоогдож, уг нэмэгдсэн жилд ногдох тэтгэвэрт 10.5 тэрбум төгрөг зарцуулсан.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэв.

“Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хууль”-ийн дагуу 16.2 мянган малчин, 1.3 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 17.7 мянган хүн 34.5 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлж, 2020 онд шимтгэл нөхөн төлсөн 8 348 иргэн шинээр тэтгэвэр тогтоолгон, тэдгээрийн тэтгэвэрт 15.9 тэрбум төгрөг зарцуулсан.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.

НД-ын байгууллагаас 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтыг чиглэл болгон 83 ажил үйлчилгээ, арга хэмжээг чиг үүргийн дагуу хийж

гүйцэтгэхээр боловсруулжээ. Төлөвлөгөөний ажил, үйлчилгээ, арга хэмжээний биелэлт тус бүрт хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэхэд нийт хэрэгжилт 95.8 хувь байна. Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний 76 нь “үр дүнтэй”, 4 нь “тодорхой үр дүнд хүрсэн”, 3 нь “үнэлэх боломжгүй” гэж үнэлэгдсэн нь төлөвлөлт, түүний биелэлт, хэрэгжилтийн байдал байгууллагын төсөв, санхүү, дотоод үйл ажиллагаа хэвийн “тодорхой үр дүнд” хүрсэн.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь дунд хугацааны буюу 2019 – 2022 оны стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлснээр нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг үр дүнтэй хийж гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгалын санд 2020 оны жилийн эцсийн байдлаар шимтгэлийн орлого 1,411.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,477.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 104.6 хувиар биелүүлж, 657.2 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 2,451.8 тэрбум төгрөг зарцуулсан.

Цар тахлын энэ хүнд үед 38.4 мянган ажил олгогч, 410.6 мянган даатгуулагч, 156.5 мянган сайн дурын даатгуулагчид нийт дүнгээр 713.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн. Эдийн засгийн байдал хэдий хүнд байсан ч тэтгэврийн хэмжээг 8 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 300.0 мянган төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 416.1 мянган төгрөгт хүрсэн.

Цаашид Засгийн газраас дэвшүүлж буй “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулж ил тод, шуурхай болгох зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан 2021 оныг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Эерэг хандлага-цахим үйлчилгээний хөгжүүлэлтийн жил” болгон зарлаж, дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр цахимаар бүртгэх боломжийг бүрдүүлж, анхан шатны бүртгэлийн баримтуудыг цахимжуулах, цахим нийгмийн даатгалын дэвтрийг нэвтрүүлэх;
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу 2021 оны 01 сараас 2021 оны 07 сар хүртэл 6 сарын хугацаанд ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалын 8.5 хувийн шимтгэлийг тус бүр төлөх, бусад төрлийн шимтгэлээс чөлөөлөх ажлыг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах ажлыг зохион байгуулах;
- Өндөр насны тэтгэвэр тогтоохтой холбоотой 2021 онд мөрдөх хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах;

- Тэтгэмжийн тайланг цахимжуулах;
- Эмнэлгийн хуудсыг цахимжуулах ажлыг хэрэгжүүлэх;
- Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн асуудлын хүрээнд холбогдох саналыг болосвруулан ХНХЯ-д хүргүүлэх;
- Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдыг шинээр хамруулах ажлыг зохион байгуулах;
- ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ХНХЯ, ХАБЭАУХ, ХАБЭМТ, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоох, олгох ажлыг зохион байгуулан, хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр төв, орон нутгийн албадыг арга зүйгээр хангаж ажиллах;
- ISO9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;
- Азийн хөгжлийн банкны төслөөр нэвтрүүлэх нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг турших, нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэгч компанийтай хамтран хэрэгжүүлэх;
- Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягтыг цахимжуулахтай холбоотой мэдээллийн технологийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх;
- Нэрийн дансны 2020 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчдад мэдээлэл хүргэх;

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид нийгмийн даатгалын үйлчилгээг шаардлагатай үедээ орон зай, цаг хугацаа үл хамааран хүртэх нөхцөл бүрдэнэ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА